ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр    Дугаар 01    Зуунмод

"Төв аймгийн хөгжлийн 2022 оны
төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн "Төв аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, түүнд Хурлын хороодоос хийсэн дүгнэлт, Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг ХЭЛЭЛЦЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.17, 48.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний дэвшүүлсэн 52 зорилт, 257 арга хэмжээний хэрэгжилтийг 90.98 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.

2. Тус төлөвлөгөөнөөс эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг "Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-нд тусган батлсныг бүрэн хэрэгжүүлж, үр дүнд хүргэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодод даалгасугай.

ДАРГА    Ц.ЖАМБАЛСҮРЭН

4123010001

Togtool-ITH-2023